



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 04 өдөр


Дугаар 22

Улаанбаатар хот

Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалт, мөн зүйлийн 34.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.7 дахь хэсэг, Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 325 дугаар тогтоол, Төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж буй үйл ажиллагааны 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн тайлангийн хурлын 2020/001 дугаартай тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилгын салбарын хот төлөвлөлт, архитекторын чиглэлийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг "Монголын архитекторуудын эвлэл" төрийн бус байгууллагаар 3 /гурван/ жилийн хугацаатай гэрээний үндсэн дээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлсүгэй.
2. "Монголын архитекторуудын эвлэл" төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх чиг үүрэг, үйл ажиллагаа, эрх хэмжээг тодорхойлон гэрээ байгуулж, энэ тушаал болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д үүрэг болгосугай.
3. "Монголын архитекторуудын эвлэл" төрийн бус байгууллага /Э.Хүрэлбаатар/-д дараах үүргийг даалгасугай:
 - 3.1. Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталсан "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм", гэрээний дагуу сургалтын үйл ажиллагааг салбарын хөгжлийн хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн чанартай зохион байгуулах;
 - 3.2. сургалтын хөтөлбөрийг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх "Барилгын салбарын ажилтныг тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл"-өөр батлуулах;
 - 3.3. үйл ажиллагаагаа хагас, бүтэн жил тутам тайлагнаж, Барилга, хот байгуулалтын яам, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг сургалтын талаарх шаардлагатай мэдээллээр тогтмол хангах.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 170 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Х.БАДЕЛХАН

151010069